

**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 4 ДҮГЭЭР
АНГИАС ХҮН БА БАЙГАЛЬ, МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛҮҮДИЙН НЭГДМЭЛ АГУУЛГААР АВАХ
ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

Сурагчийн нэр:

Хугацаа: 40 минут

Нийт: 27 оноо

СОНГОХ ДААЛГАВАР

А ХУВИЛБАР

Нарс, хуш, зээргэнэ мөнх ногоон болсны учир

Эрт цагт нэгэн сайн санаат хараацай үхэлгүй мөнхийн рашаан усыг хүнд уулгах гэж хэдэн дуслыг амандаа балгаад нисэж явж байжээ. Гэтэл хорон муу санаатай үхэр хэдгэнэ үүнийг мэдээд хараацайг нисэн явах зуурт хажуу талаас нь хатгаж орхижээ. Хараацай шувуу өвдөхийн эрхээр дуу алдан ёолсонд аман дахь мөнхийн усаа асгаж гэнэ.

Асгарсан тэр рашаан нь нарс, хуш, зээргэнэ гурав дээр дуссан учир энэ гурван ургамал мөнх ногоон шилмүүс навчтай болсон ажээ. Хамаг хэргээ талаар болгосон хараацай шувуу харамсан цухалдахдаа хэдгэний хэлийг суга татсан учир тэр цагаас хойш хэдгэнэ уянгатай сайхан донгодож чадахаа байгаад дэмий л дүнгэнэдэг болсон юм байжээ.

1. Хараацай юу балгаад явж байсан бэ? \1 оноо

- А. Дусал ус
- Б. Мөнхийн рашаан ус
- В. Рашаан
- Г. Ус

2. Хэдгэнэ яагаад дүнгэнэдэг болсон бэ? \1 оноо

- А. Хоолой нь сөөсөн
- Б. Хэлгүй болсон
- В. Сайхан донгодож чаддаггүй байсан
- Г. Хатгадаг учраас дүнгэнэдэг

3. Хараацай амандаа балгаж явсан усаа яагаад асгачихсан бэ? \1 оноо

.....
.....

4. Ямар 3 мөнх ногоон ургамал байдаг вэ? \1 оноо

.....

5. Дараах өгүүлбэр дэх алдаатай үгийг засаж бичээрэй. \1 оноо

Ном их уншия. Эрдэмд суралцая.

.....


6. Хэрэв хүнд мөнхийн рашааныг уулгасан бол хүн ямар болох байсан бол? Таамаглан бичээрэй. \1 оноо

.....

6. Дараах өгөгдлийг зөв холбо. \3 оноо

- 1. Хатуу а. жижиг хэсгүүд эмх замбараагүй хөдлөх бөгөөд хоорондын зай их байна.
- 2. Шингэн б. жижиг хэсгүүд маш нягт, эмх цэгцтэй байрлаж, хоорондын зай бага байна.
- 3. Хий в. жижиг хэсгүүдийн хоорондын зай хатуугийнхаас арай их байна.

7. Дараах зургуудыг зөв холбож зураарай. \3 оноо



**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 4 ДҮГЭЭР
АНГИАС ХҮН БА БАЙГАЛЬ, МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛҮҮДИЙН НЭГДМЭЛ АГУУЛГААР АВАХ
ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

“Б” ХУВИЛБАР

Сурагчийн нэр:

Хугацаа: 40 минут

Нийт: 27 оноо

Буга

Буга ус уухаар гол дээр ирж, өөрийнхөө усанд туссан дүрсийг харан том даргар эврээрээ бахархан, хөлөө харж: - Миний хөл даанч турьгүй, нарийхан, доожоогүй юм гэж үглэж байв.

Гэнэт арслан гарч ирэн, буга руу дайрав. Буга уужим талаар хар хурдаараа зугтаж баригдалгүй явснаа ойд ормогц эвэр нь модонд тээглэн ороолдож, арсланд баригдчихжээ.

Буга амь үрэгдэхийн даваан дээр “ Ямар хачин юм бэ? Би эврээ ямар гоё юм бэ? гэж бахдаж байсан юм сан. Голж байсан нарийхан хөл минь аюулаас аварч, бахдан дэнхгэнүүлж байсан даргар эвэр маань намайг аюулд унагадаг байна шүү. Аливаа юмыг үзэгдэх хэлбэр, өнгөөр нь үнэлж цэгнэж болдоггүй юм байна” гэж бодов.

1. Үлгэрийн үтгэд тохирох зүйр үгийг сонгоорой. /1 оноо/

А. Зөв олон талтай Б. Өөдөө хаясан чулуу В. Буруу ганц талтай Г.Өөрийн толгой дээр

2. Буга гол дээр ус уухаар очоод усанд туссан дүрсээ хараад юугаараа бахархсан бэ? /1 оноо/

А. Турьгүй нарийн хөл Б.Даргар эвэр В.Доожоогүй хөл

3. Бугаар ямар хүний зан чанарыг төлөөлөн үзүүлсэн бэ? /1 оноо/

А. Онгироо Б. Даруу В. Сэргэлэн

4. Буга яагаад баригдсан бэ? /1 оноо/

.....

5. Дараах өгүүлбэр дэх алдаатай үгийг засаж бичээрэй. \1 оноо

Ном уншия. Гар бария

.....

6. Хэрэв чи буга байсан бол Таамаглан бичээрэй. \1 оноо

.....

ЗАДГАЙ ДААЛГАВАР:

1. я, е, ё- залган бичээрэй 3 оноо

үз- бод- дуул-

ажигла- хорь- хая,

**2. Урилга бичих дарааллыг бичээрэй \ 3 оноо **

А..... Б.....
В..... Г.....

3. Бугийг зугтахад юу тусалсан бэ? \3 оноо

.....
.....

ХҮН БА БАЙГАЛЬ

1. Амьд биед юу хэрэгтэй вэ? \1 оноо

- А. мод, нар, ус
Б. нарны гэрэл, зам, дулаан
В. агаар, нарны гэрэл, ус, хөрс
Г. үйлдвэр, хөрс, ус, агаар

2. Дараах зураг юуны зураг байна вэ? \1 оноо



.....

.....

3. Ус ба хуурай газрын аль алинд амьдардаг амьтдыг юу гэдэг вэ? \1 оноо

- А. Усны амьтад
Б. Хоёр нутагтан
В. Хуурай газрын амьтан.

4. Цэгийн оронд тохирох үгийг сонгоорой. \1 оноо

Ногоон ургамал хоол тэжээлийн зүйлсийг бүтээдэг тул тэднийг гэж нэрлэдэг.

- А. Бүтээгчид
Б. Хэрэглэгчид
В. Ургамал идэштэн
Г. Холимог идэштэн

**5. Ургамлын улирлын өөрчлөлтийг харгалзуулан холбо. \3 оноо **

- | | | |
|----------|-------------|----------------|
| 1. хавар | а. шарлах | А. 1г 2в 3а 4б |
| 2. зун | б. нүцгэрэх | Б. 1б 2а 3в 4г |
| 3. намар | в. ногоорох | В. 1а 2б 3г 4в |
| 4. өвөл | г. Борлох | Г. 1в 2г 3а 4б |

**6. Дараах өгөгдлийг зөв холбо. \3 оноо **

- | | |
|-----------|---|
| 1. Хатуу | а. жижиг хэсгүүд эмх замбараагүй хөдлөх бөгөөд хоорондын зай их байна. |
| 2. Шингэн | б. жижиг хэсгүүд маш нягт, эмх цэгцтэй байрлаж, хоорондын зай бага байна. |
| 3. Хий | в. жижиг хэсгүүдийн хоорондын зай хатуугийнхаас арай их байна. |


7. Дараах зургийн ажиглан дугаарыг нь бичээрэй. 3 оноо \хатуу- шингэн- хий- \



1



2



3

ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН ЕБС-ЫН 4А АНГИЙН “МАТЕМАТИК” ХИЧЭЭЛИЙН АНГИ
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

Сурагчийн нэр.....

40 минут

СОНГОХ ДААЛГАВАР

В хувилбар

Сайхан сэтгэл

Бүргэдийн ангаахай үүрнээсээ толгойгоо цухуйлган хадан хясааны доогуур эргэлдэн нисэж байгаа олон шувууг ажиглажээ.

-Ээжээ, энэ юун олон шувуу вэ? гэж ангаахай асуув.

-Бидний анд нөхөд байна. Бүргэд ганцаараа амьдардаг шувуу. Гэхдээ хааяа тэдэнд найз нөхөд хэрэгтэй. Тэгэхгүй бол бүргэд юуных нь шувуудын хаан байх билээ. Чиний харж байгаа бүх шувууд бидний анд нөхөд гэж ээж бүргэд ангаахайдаа хэллээ. Ээжийнхээ хэлсэн үгийг ангаахай сайтар бодоод тэднийг анд нөхдөө гэж санах болов. Тэгснээ гэнэт чарлаж:

-Хүүе, тэд нар манай хоолыг хулгайлж байна гэв.

-Тайвшир даа. Үр минь, тэд биднээс юу ч хулгайлаагүй. Би тэднийг өөрөө дайлсан юм. Бүргэд өөрөө хэчнээн өлсөж байлаа ч дэргэдээ байгаа шувуутай хоолоо хувааж иддэг жамтай. Ийм өндөрт байгаа шувууд хоол олж идэхэд хэцүү тул бие биеэ дэмжиж тусалдаг юм гэжээ.

Үнэнч сайн нөхөдтэй байя гэж бодсон хэн ч бусдын гачигдлыг анхаарч байх хэрэгтэй юм.

1. Бүргэд ангаахайтайгаа хаана амьдардаг вэ? \1 оноо

А. Хадан хясааны дээр Б. Өндөр ууланд В. Тэнгэрт Г. Нүхэнд

2. Бүргэд яагаад шувуудын хаан бэ? \1 оноо

А. Найз нөхөд ихтэй Б. Хоолоо бусад шувуунд алдсан
В. Өвдсөн Г. Том биетэй учраас

3. Ээжийнхээ хэлсэн үгийг сонссон ангаахай юуг ухаарсан бэ? \1 оноо

.....
.....

4. Үнэнч сайн нөхөдтэй байхын тулд ямар байх хэрэгтэй вэ? Өөрийн бодлыг бичээрэй. \2 оноо

.....
.....

5. Дараах өгүүлбэр дэх алдаатай үгийг засаж бичээрэй.\1 оноо

Үсээ самнууля . Эцэг эхээ хүндэл

.....

А. Бүтээгчид

Б. Хэрэглэгчид

В. Ургамал идэштэн

Г. Холимог идэштэн


**5. Ургамлын улирлын өөрчлөлтийг харгалзуулан холбо. \3 оноо **

- | | | |
|----------|-------------|----------------|
| 1. хавар | а. шарлах | А. 1г 2в 3а 4б |
| 2. зун | б. нүцгэрэх | Б. 1б 2а 3в 4г |
| 3. намар | в. ногоорох | В. 1а 2б 3г 4в |
| 4. өвөл | г. Борлох | Г. 1в 2г 3а 4б |

6. Дараах өгөгдлийг зөв холбо.





- | | |
|-----------|---|
| 1. Хатуу | а. жижиг хэсгүүд эмх замбараагүй хөдлөх бөгөөд хоорондын зай их байна. |
| 2. Шингэн | б. жижиг хэсгүүд маш нягт, эмх цэгцтэй байрлаж, хоорондын зай бага байна. |
| 3. Хий | в. жижиг хэсгүүдийн хоорондын зай хатуугийнхаас арай их байна. |

7. Дараах зургуудыг зөв холбож зураарай. 3 оноо



ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ ЕБС-ИЙН 4 ДҮГЭЭР АНГИЙН “МАТЕМАТИК” ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВРЫН ТҮЛХҮҮР

СОНГОХ ДААЛГАВАР					
№	А	Б	В	Г	ОНОО
1.	Г	Б	В	Б	1
2.	В	А	Г	В	1
3.	В	А	А	А	1
4.	В	В	А	Б	1
5.	Б	Г	А	Г	1
6.	А	В	Б	В	1
7.	Г	В	Б	В	1
8.	Б	Г	А	А	1
9.	В	Г	Г	Г	1
10.	А	В	В	В	1
Нийт	10 даалгавар				10

ЗАДГАЙ ДААЛГАВАР					
№	А хувилбар	Б хувилбар	В хувилбар	Г хувилбар	ОНОО
1.	$32:8=4$ $4 \times 3=12$ англи хэл $32:4=8$ япон хэл $12+8=20$ нийт	$48:8=6$ $6 \times 3=18$ англи хэл $48:4=12$ япон хэл $18+12=30$ нийт	$36:6=6$ $6 \times 3=18$ англи хэл $36:4=9$ япон хэл $18+9=27$ нийт	$27:9=3$ $3 \times 3=9$ англи хэл $27:3=9$ япон хэл $9+9=18$ нийт	3
2.	$\frac{9}{25} \quad \frac{6}{20}$	$\frac{4}{30} \quad \frac{13}{45}$	$\frac{4}{30} \quad \frac{13}{45}$	$\frac{4}{30} \quad \frac{13}{45}$	2
3.	1. $4 \times 10=40\text{см}$ $40 \times 2=80\text{см.куб}$ 2. $10 \times 2=20\text{см}$ $20 \times 4=80\text{см.куб}$	1. $4 \times 10=40\text{см}$ $40 \times 2=80\text{см.куб}$ 2. $10 \times 2=20\text{см}$ $20 \times 4=80\text{см.куб}$	1. $4 \times 8=32 \text{ см}$ $32 \times 2=64\text{см.куб}$ 2. $2 \times 8=16\text{см}$ $16 \times 4=64\text{см.куб}$	1. $4 \times 10=40\text{см}$ $40 \times 2=80\text{см.куб}$ 2. $10 \times 2=20\text{см}$ $20 \times 4=80\text{см.куб}$	3
4.	$4 \times 3=12$ боломж Хялбар эсвэл модны арга ашиглах.	$6 \times 3=18$ боломж Хялбар эсвэл модны арга ашиглах.	$4 \times 4=16$ боломж Хялбар эсвэл модны арга ашиглах.	$4 \times 3=12$ боломж Хялбар эсвэл модны арга ашиглах.	3
5	 <p>Гурвалжны дотоод өнцөг 180 байдгийг мэдэж байх Тэгш өнцөгт гурвалжны өнцөг 90 байдгийг мэдэж байх. Хариу 35.</p>	 <p>Гурвалжны дотоод өнцөг 180 байдгийг мэдэж байх Адил хажуут гурвалжны суурийн өнцөг ижил байдгийг мэдэж байх</p>	 <p>Гурвалжны дотоод өнцөг 180 байдгийг мэдэж байх Адил хажуут гурвалжны суурийн өнцөг ижил</p>	 <p>Гурвалжны дотоод өнцөг 180 байдгийг мэдэж байх Адил хажуут гурвалжны суурийн өнцөг ижил</p>	3

		Хариу 50	байдгийг мэдэж байх Хариу 50	өнцөг ижил байдгийг мэдэж байх Хариу 60	
	Нийт: 5 ДААЛГАВАР				14